



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Г

Г

Зөвшөөрөл олгох тухай


Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтооюур баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ыг тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, хүнсний асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор батлахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшиүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга нарт даалгасугай.

3. Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулж, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (Ж.Эрдэнэбат)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, хүнсний, асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Б.БААТАРЗОРИГ

23000048

Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн
28 дугаар тогтоолын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Албан тушаалын нэр:

Хоол үйлдвэрлэл, үйчилгээний асуудал хариуцсан арга зүйч мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-8

Ажлын байрны албан ёсны байршил:

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хүрээнд хүүхдийн хоол, хүнсний чанар, хүртээмж, эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, тайлганах чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
2. Хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүний нөөцийг чадавхжуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах;
3. Суралцагчид болон боловсролын үйлчилгээнд оролцогч талуудад хоол шим тэжээлийн боловсрол олгох бодлогыг хэрэгжүүлэх, оролцогч талуудын оролцоог хангах;
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – X
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр гарсан хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, тайлагнах;	Бодлого шийдвэрийн хэрэгжилтийн хувь	Г, X
	2.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санал, зөвлөмж боловсруулах ;	Санал, зөвлөмж, дүгнэлт гарсан байна.	Г, X
	3. Сургууль, цэцэрлэг, дотуур байрын хоол үйлдвэрлэл үйлчилгээний хэрэгжилтэд мэргэжил арга зүй, мэдээллээр хангаж ажиллах;	Хэрэгжилтэд ахиц гарсан байна.	Г, X
	4. Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд гадаад болон дотоодын дэвшилтээт арга зүй, сайн туршлага, үйл ажиллагааг нэвтрүүлэх;	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн	Г,Х
	5.Орон нутгийн хэмжээнд сургууль, цэцэрлэг, дотуур байрын хоолны газрын нөхцөл байдлын судалгааг жил бүр хийж, хоол хүнсний аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр	Стандарт хангагдсан байна.	Г,Х



2

	санал дүгнэлт, зардлын тооцооллыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, шийдвэрлүүлэх;			
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хүүхдийн хоол хүнсний хангамжид орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжсэн, шим тэжээллэг, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд удирдлага зохион хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Хуулийн хэрэгжилтийг хangan ажилласан байна.	Г,Х	
	2.Сургуульд цэвэршүүлсэн нөхцөлийг чиглэлээр боловсруулж байгууллагуудад хүргүүлэх;	ундны ус бүрдүүлэх санал холбогдох санал	Судалгаа гаргаж, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж ажиллах	Г,Х
	3.Сургууль, цэцэрлэг, дотуур байрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх;		Мэдээллийн сан бүрдсэн байна.	Г,Х
	4.Хүний нөөцийн төлөвлөлтийн санал дүгнэлт боловсруулж, удирдлагад танилцуулж, хэрэгжүүлэх;		Судалгаанд тулгуурласан хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г,Х,Т
	5.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудыг давтан сургах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;		Ур чадвар сайжирсан байна.	Г
	6.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтны хөдөлмөрийн үр дүн, ур чадварыг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх;		Судалгаанд үндэслэн санал боловсруулж хүргүүлсэн байна.	Г,Х,Т
	7.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтны бүтээлч үйл ажиллагааг сурталчлан таниулах, дэмжих,		Бодлого шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна.	



	түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;		
3 дугаар зорилтын хүрээнд	1.Иргэд, олон нийтийн хоол шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, мэдээллээр хангаж ажиллах;	Нэлөөллийн ажил зохион байгуулсан байна.	Г,Х
	2.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнууд болон боловсролын үйлчилгээнд оролцогч талуудад зориулсан сургалт зохион байгуулах нэгдсэн удирдлагаар хангах, гарын авлага зөвлөмж боловсруулах, түгээх;	Сургалт зохион байгуулж, үр дүн гарсан байна.	Г,Х
	3.Төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хүүхдийн эрүүл мэнд, ёсөлт, хөгжилт, хоол тэжээлийн судалгааг гаргаж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлэх;	Нэгдсэн судалгаа гаргаж, тайлагнасан байна.	Г,Х,Т
	4.Эрүүл мэндийн хичээлээр дамжуулан хоол шим тэжээлийн боловсрол олгож буй эсэхэд хяналт тавих;	Санал боловсруулж хүргүүлсэн байна.	Г,Х,Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх;	Төрийн албаны тухай хууль бусад дүрэм, журмыг зөрчөөгүй нотлох дүгнэлт гаргасан байна.	Г
	2.Газар, хэлтсийн удирдлага бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх;	Цаг хугацаанд чанартай гүйцэтгэсэн байна.	Г
	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлэх;	Стандартыг мөрдөж ажилласан байна.	



	4. Төрийн болон төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө мэдээлэл өгөх, харилцан солилцох;	Чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Г
--	--	---------------------------------	---

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	Хоол зүй, шим судлал /072102/ Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи /072105/		
Мэргэшил	Төрийн албанад мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Мэргэжлээрээ 2-аас доошгүй жил ажилласан байх		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх; - статистик мэдээлэл, арга хэрэгслийг ашиглах чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; нэгтгэж дүгнэх, анализ хийх, тайлгнах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - бусад. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түиэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - шинэ технологи, инновацийг туршдаг, хэрэгжүүлдэг байх; - хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх, хууль эрхзүйн мэдлэгтэй байх; - асуудлын шийдлийн хувилбарыг оновчтой тодорхойлох; - шинийг санаачлах, өөрчлөлт шинэчлэлтийг дэмждэг байх; - үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - оновчтой төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих; -бусад. 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи, техник хэрэгсэл ашиглах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; <p>төрийн болон хувь хүний нууцыг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах.</p>	

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Албан тушаалд шууд харьялан
удирдуулах албан тушаалын
нэр, тоо:

-Байхгүй

Бусад харилцах субъект

- Боловсрол, шинжлэх ухааны яам,
- Боловсролын ерөнхий газар,
- Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
- Боловсролын үнэлгээний төв
- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
- Төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуулиуд
- Аймгийн ИТХ
- Аймаг, сумын ЗДТГ
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага төсөл хөтөлбөрүүд
- Иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:

.....
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ШИЙДВЭРИЙН ОГНОО

Дугаар

23 0201

028

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ШИЙДВЭРИЙН ОГНОО

Дугаар

(тамга/тэмдэг)

ДАРГА

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

